

Зах зээлийн эргэлтийн цэг: EBC Financial Group нь тахлын дараах төв банкуудын бодлогын зөрүүнд дүн шинжилгээ хийж байна

АНУ-ын гаалийн татвар, Евро бүсийн мөнгөний хөнгөлөлт, геополитикийн эрсдэл нэмэгдэж байгаа зэргээс шалтгаалж дэлхийн зээлийн хүү өөр өөр байна.

DC, UNITED STATES, May 20, 2025

/EINPresswire.com/ -- Төв банкууд нэгэн жигд алхаж байсан цаг үе ард үлдэж, өнөөдөр арилжаачид огт өөр, хуваагдсан мөнгөний бодлогын орчинтой нүүр тулж байна. 5-р сарын 7-нд АНУ-ын Холбооны Нөөцийн Сан (Federal Reserve) инфляцийн эрсдэл хэвээр байсаар, худалдааны бодлогын хурцадмал байдал нэмэгдсээр байгаа ч хүүг 4.25%-4.50%-ийн хооронд хадгалахаар шийдвэрлэв. Харин Европын Төв Банк 4-р сард бодлогын хүүгээ бууруулсан бөгөөд өнөөдөр гэхэд Их Британийн Төв Банк ч мөн адил шийдвэр гаргаж магадгүй гэсэн хүлээлт зах зээлд давамгайлж байна.

Эдгээр үйл явдлын дунд дэлхий даяар зохицуулалттай брокерийн үйлчилгээ үзүүлдэг [EBC](#) Санхүүгийн Групп мөнгөний бодлогын энэ ялгаа нэмэгдэж, Энэтхэг-Пакистаны хурцадмал байдал зэрэг шинэ геополитикийн эрсдэлүүдтэй хослон арилжаачдын стратегид томоохон өөрчлөлт авчирч, хэлбэлзэлтэй зах зээлд баримжаатай, мэдлэгт тулгуурласан чиглүүлэлт эрэлттэй болоод байгааг онцолж байна.

“Цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийн үеэс хойш бид төв банкуудын бодлогын ийм хэмжээний зөрүүг анх удаа харж байна” хэмээн EBC Санхүүгийн Групп (UK) ХХК-ийн Гүйцэтгэх захирал Дэвид Барретт хэлэв. “Холбооны Нөөцийн Сан хатуу байр суурь барьж



Дэлхийн зах зээлүүд мөнгөний зөрүүтэй бодлоготой тулгарч байгаа энэ үед EBC Financial Group нь АНУ-ын Холбооны Нөөцийн сангийн хүүг барих нөлөөлөл, ECB-ийн саяхны бууралт, бүс нутгийн геополитикийн хурцадмал байдлын нөлөөллийг задлав.

байгаа бол Европын Төв Банк аль хэдийн зөөлрүүлэх бодлого эхлүүлсэн. Харин Их Британийн Төв Банк ч дагаж магадгүй. Арилжаачдын хувьд хүүгийн түвшинг дагах нь хангалтгүй – харин яагаад замууд ялгаатай болж байгаа нь, дэлхий дахины байрлалаа хэрхэн тодорхойлох нь илүү чухал болж байна.”

The Fed Hits Pause—But Uncertainty Pushes Play

While the Fed held rates steady, citing a great deal of uncertainty surrounding inflation and the economic effects of new tariffs introduced by President Donald Trump, the European Central Bank broke from its tightening stance last month, lowering its deposit rate by 25 basis points to 2.25%—marking its first rate cut since the pandemic-era normalisation began. This divergence highlights a growing split in how major economies are responding to inflation dynamics, trade-related pressures, and weakening growth indicators.

Fed Chair Jerome Powell's emphasis on caution—driven in part by uncertainty over the inflationary impact of renewed U.S. tariffs—contrasts with the European Central Bank's recent pivot toward growth support, as it cut rates to counter flagging momentum across the Eurozone.

Холбооны Нөөцийн Сан түр азнасан ч, тодорхойгүй байдал тоглуулж байна

АНУ-ын Холбооны Нөөцийн Сан (Fed) бодлогын хүүг хэвээр үлдээсэн ч инфляц болон Ерөнхийлөгч Дональд Трампын шинээр нэвтрүүлсэн тарифуудын эдийн засагт үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой тодорхойгүй байдал өндөр байгааг онцолсон юм. Үүний зэрэгцээ Европын Төв Банк өнгөрсөн сард хүүг 25 нэгжийн үзүүлэлтээр бууруулж 2.25% болгож, цар тахлын дараах “хатуу” бодлогоос анх удаа зөөлрүүлэх чиглэлд шилжлээ.

Энэ нь голлох эдийн засгууд инфляцын төлөв, худалдаатай холбоотой дарамт, эдийн засгийн өсөлтийн сулрал зэрэгт харилцан адилгүй хариу үйлдэл үзүүлж буйг тод харуулж байна.

Fed-ийн дарга Жером Пауэллийн болгоомжлолыг уриалсан байр суурь—ялангуяа шинэ тарифын инфляцид үзүүлэх нөлөө тодорхойгүй байгаагаар холбоотой—нь Европын Төв Банкны эдийн засгийн идэвхжлийг дэмжих шийдвэртэй эрс ялгаатай байна. Евро бүсийн уналтад орж буй эрчийг сааруулахын тулд ЕТБ хүүг бууруулсан нь бодлогын зөрүү улам гүнзгийрч байгааг харуулж байна.

Бүх төрлийн хөрөнгийн зах зээл дээр арилжаачид зөвхөн тоон мэдээлэлд бус, дэлхий нийтээр дагаж мөрдөх нэгдмэл чиг хандлага үгүй болсонд ч мөн зохицон өөрчлөгдөж байна. Зарим төв банк зөөлрүүлэх бодлого руу шилжиж байхад, зарим нь хүүгээ хадгалж, харин нөгөөдүүл нь инфляцын дарамтад хэвээр байна — энэ бүхний дунд уламжлалт үзүүлэлтүүд бүгдэд ижил утгатай байхаа больж, зам харгуй улам бүр төвөгтэй болжээ.

“Одоо бол ажиглаад суух цаг биш” хэмээн ЕВССанхүүгийн Групп (UK) ХХК-ийн гүйцэтгэх захирал Дэвид Барретт онцоллоо. “Энэ бол арилжаачид идэвхтэй тайлбарлаж, дасан зохицож, мэдээлэлтэй байж сурах үе. Харин бидний үүрэг бол ЕВС-д хэрэглэгчдэд бодит цагийн ойлголт, чиглэл өгч, зах зээл хуваагдсан ч ухаалаг шийдвэр гаргахад нь туслах явдал юм.”

Дэлхий даяарх мөнгөний бодлогын зөрүү хурцдаж буй энэ үед ч ЕВС өөрийн эрхэм зорилгод үнэнч хэвээр: арилжаачдыг боловсрол, ил тод байдал, дэлхийн түвшний шинжилгээгээр дэмжих.

Дэлхийн гол санхүүгийн зах зээлүүдэд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг ЕВС нь хэрэглэгчдэд институцийн чанартай арилжааны платформ, олон хэл дээрх зах зээлийн дүн шинжилгээ, макро эдийн засгийн нөхцөл байдалд нийцсэн мэргэжилтний сэтгэгдлийг үргэлж хүргэсээр байна.

Үүнээс үл хамааран—хүүгийн мөчлөг, бүс нутгийн хурцадмал байдал, эсвэл түүхий эдийн үнийн хэлбэлзэл—ЕВС арилжаачдад эргэлзээ бус итгэлтэйгээр алхахад шаардлагатай бүх орчныг бүрдүүлж өгдөг. Дэлгэрэнгүй мэдээллийг бидний албан ёсны вэбсайтаас авна уу: <https://www.ebc.com>.

###

ЕВС Санхүүгийн Группийн Тухай

Лондон хотын санхүүгийн төвд үүсгэн байгуулагдсан ЕВС Санхүүгийн Групп хөрөнгө удирдлага, брокерийн үйлчилгээний чиглэлээр олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг. Лондон, Сидней, Хонконг, Сингапур, Кайманы арлууд, Бангкок, Лимассол зэрэг дэлхийн томоохон санхүүгийн төвүүдэд салбартай тус компани хувь хүн болон байгууллагуудад валют, түүхий эд, хувьцаа, индекс зэрэг олон төрлийн санхүүгийн зах зээлд шууд нэвтрэх боломжийг олгодог.

Компанийн бүс нутгийн салбарууд харьяа улсынхаа зохицуулах байгууллагаар зохицуулагддаг бөгөөд ёс зүй, ил тод байдлыг гол зарчим болгож ажилладаг. ЕВС Санхүүгийн Групп (UK) Limited нь Их Британийн Санхүүгийн Үйлчилгээний Хорооны (FCA) харьяанд, ЕВС Санхүүгийн Групп (Cayman) Limited нь Кайманы Арлуудын Санхүүгийн Зохицуулах Газраар (CIMA), харин Австралийн салбарууд нь Австралийн Үнэт Цаас ба Хөрөнгө Оруулалтын Комиссын (ASIC), EBC Financial (MU) Ltd Маврикийн Санхүүгийн Үйлчилгээний Хорооны (FSC) зохицуулалтад тус тус хамаардаг.

40 гаруй жилийн туршлага бүхий санхүүгийн мэргэжилтнүүдээс бүрдсэн ЕВС-ийн баг Плазацийн Гэрээ, 2015 оны Швейцар франкийн хямрал, COVID-19 цар тахлын үеийн зах зээлийн савлагаа зэрэг дэлхийн томоохон эдийн засгийн мөчлөгүүдийг даван туулж ирсэн туршлагатай. Компанийн соёл нь шударга байдал, харилцан хүндлэл, хөрөнгө

хамгаалалтыг нэн тэргүүнд тавьж, хөрөнгө оруулагч бүрийн харилцааг онцгой ач холбогдолтойгоор хүлээн авч, хүндэтгэлтэй ханддаг зарчимд тулгуурладаг.

ЕВС Санхүүгийн Групп алдарт FC Barcelona клубын Албан ёсны Гадаад Валютын Түнш байгууллага бөгөөд Ази, Латин Америк, Ойрхи Дорнод, Африк болон Номхон далайн бүс нутгуудад тусгай чиглэлийн санхүүгийн

үйлчилгээ үзүүлдэг. НҮБ-ын Сан болон дэлхийн хамгийн том оролцоонд суурилсан кампанит ажил болох “United to Beat Malaria” хөтөлбөрийн түншлэлийн хүрээнд дэлхийн эрүүл мэндийн санаачлагуудад хувь нэмэр оруулж байна.

Мөн ЕВС Оксфордын Их Сургуулийн Эдийн Засгийн Тэнхимийн хэрэгжүүлдэг “Эдийн засагчид юу хийдэг вэ?” олон нийтэд зориулсан боловсролын цувралыг дэмжин оролцож, эдийн засгийн ойлголтыг олон нийтэд энгийн, хүртээмжтэй байдлаар хүргэж, нийгмийн тулгамдсан асуудлуудын талаарх ойлголт, хэлэлцүүлгийг гүнзгийрүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

<https://www.ebc.com/>

Michelle Siow
EBC Financial Group
+ +60 163376040

[email us here](#)

Visit us on social media:

[LinkedIn](#)

[Instagram](#)

[Facebook](#)

[YouTube](#)

[X](#)

[Other](#)

This press release can be viewed online at: <https://www.einpresswire.com/article/814243318>

EIN Presswire's priority is source transparency. We do not allow opaque clients, and our editors try to be careful about weeding out false and misleading content. As a user, if you see something we have missed, please do bring it to our attention. Your help is welcome. EIN Presswire, Everyone's Internet News Presswire™, tries to define some of the boundaries that are reasonable in today's world. Please see our Editorial Guidelines for more information.

© 1995-2025 Newsmatics Inc. All Right Reserved.